



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 едер

Дугаар 11252

Арвайхээр сум

### Тендериийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар дүгнэлтийн дагуу Есөнзүйл сумын дотуур байрын засварын ажлыг 63,456,239 (жаран гурван сая дөрвөн зуун тавин зургаан мянга хоёр зуун гучин ес) төгрөгөөр Галбын тос ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгжид гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0471

D:My Doc. Zahiramj. Zasag darga